



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 11 сарын 06 өдөр

Дугаар А/413

Улаанбаатар хот

**Хөрөнгө хүлээн авах ажлын хэсэг  
байгуулах тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын “Эрх шилжүүлэх тухай” 2019 оны А/529 дүгээр захирамж, Хан-Уул дүүргийн Засаг даргын “Үнэлгээний хороо байгуулах тухай” 2019 оны А/236 дугаар захирамжаар байгуулагдсан Үнэлгээний хорооны зөвлөмжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хаштехник” ХХК-тай байгуулсан “Хан-Уул дүүрэгт хог тээврийн автомашин нийлүүлэх гэрээ” ХУД2019/НТХ-А529 дугаартай гэрээний дагуу нийлүүлэгдэж буй хөрөнгийг хүлээн авах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.

2. Хог тээврийн автомашиныг тендерийн баримт бичиг, техникийн тодорхойлолтын дагуу хүлээн авах ажлыг зохион байгуулахыг ажлын хэсэг /С.Ариунжаргал/-т даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга /Д.Рэнцэнбямба/-д үүрэг болгосугай.


ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

115050001225

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2019 оны 11 дүгээр сарын 06 ны өдрийн А/Н/З дугаар тушаалын хавсралт



### Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч:	С.Ариунжаргал	Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн дарга
Гишүүд:	Т.Оюунсүвд	Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн
	Л.Эрдэнэбат	“Тохижилт үйлчилгээний төв” ОНӨААТҮГ-ын хангамжийн мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/
	Ч.Мянган	Хан-Уул дүүргийн Санхүү төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/
Нарийн бичгийн дарга:	Ч.Хоролгарав	Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн мэргэжилтэн